

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гонгорын Хэнгэрэг	Дугаар	L025
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянзүрх дүүрэг
Төрсөн газар	Төв аймгийн Авдарбаян сум	Төрсөн он	1919
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бамбар-Эрдэнэ хутагтын хийд	Сүм хийдийн дугаар	ТӨСЭ 064
Одоогийн сүм хийд	Дэчинравжаалан	Сүм хийдийн дугаар	УВ 16
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Төв аймгийн Сэргэлэн сумын Бамбар-Эрдэнэ хутагтын хийд

Би Төв аймгийн Бамбарын хүрээнд сууж байсан. Бамбарын хүрээ нь Үнээгийн овооноос хойш Эрээдэн гэдэг уулын ард байсан юм. Үнээгийн овоог тахидаг байсан. Тэр тахилга сэргэсэн. Бамбар эрдэнэ хутагт гэж надтай чацуу хүн байсан. Халхын тамгатай хутагтын нэг байсан. Бамбар-Эрдэнэ хутагт 1935, 1936 оны үед баригдаад явсан. 100 гаран ламтай. Долоон дугантай. Цогчэн, Жүд, Дүдвийн, Манбын мөн дээд сүм, доод сүм гэсэн хоёр сүм байсан. Дүдвийн дуган гэдэгтээ цанидын ном хурна. Дээд сүмдээ бурхан тахил байна. Манай хийдэд төвд нэр байгаагүй. Бамбар-Эрдэнэ хутагтын нэр нь Цэгмид гэдэг хүн байсан. Манай хийд Шавь долоон хошууны нутагт байсан юм.

Хийдийн гол шүтээн нь Дамдин сахиус, Улаан сахиус байсан. Манай хийдэд тэр л орон нутгийн хүмүүс шавилан суудаг байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манай Бамбар- Эрдэнэ багш нэг настайгаасаа тодорсон. Ээжийг нь Сийлэгмаа гэдэг байсан. Бамбар-Эрдэнэ хутагтаас өмнө Дээд лам нь гэж байсан. Дээд лам 60 дөхөж байж нас барсан. Тэгээд Бамбар –Эрдэнэ хутагт тодорсон.

Хийдийн уншлага өдөр тутам Цогчэн, Цанжид уншина. Шинийн 15-нд Жүд, 8-нд Манла, 29-нд Арван хангал уншина. Бурхан багшийн дүйчэн өдрөөр Лхам уншина. Цагаан сарын битүүнд Цэдор хурна. Шинийн нэгнээс эхлээд ерөөл уншина. Манай хийдэд цам гардаг байсан. Цам 7,8 сард гарна. Майдар эргэдэг байсан. Ганжуураа хүрээгээ тойрч эргэдэг байсан. Нүгнээ сахина. Хайлан хурна, үүнд 20-30 лам суудаг, 45 хоног үргэлжилнэ.

Шавар, чулуу, модоор барьсан дугантай байсан. 1934, 1935 онд Цогчэн дуган, Жүдийн дуган хоёр шатсан. Тэгэхэд багш байсан. За яахав, яахав гэж байсан. Дахиж дуган нэмж бариагүй. Тэр үед чинь хүрээг үймүүлсэн янз бүрийн улсууд их байсан.

Би уншлага төгсгөөд жүдэд нэг орсон болоод байтал хийд хаагдаж хар болсон. Нэг жил л болсон. Тэрнээс илүү байгаагүй. Жүдийг уншсан хүний салхин дээгүүр нь гарахад гурван муу заяанд төрөхгүй гэдэг юм.

Дугаржав гэж хамба байсан. Жүдийн хамба нь Түвдэн гэж байсан. Унзадууд зөндөө. Мөрдорж, Жамц гэж байсан. Цогчэн унзад жүдийн унзад болно. Бамбар-Эрдэнэ хутагт бол хүрээний тэргүүн.

Манай хийдийн тэрүүхэн ойр хавьд хийд байгаагүй. Хүрээтэй л харилцаатай байсан байх. Манайд төвд лам байгаагүй. Хийд хэрмэн хашаа байхгүй суварга хэд хэд байсан. Үнээгийн овооны энгэрт гурван суварга байсан. Лам нарын хашаа байшин нь хүрээнийхээ баруун, зүүн хоёр талаараа байдаг. Хийдийн ойролцоо энгийн айлууд зөндөө байсан.

Нэг жастай, жас нь өргөл барьцаар амьдардаг байсан. Мал гэж цөөхөн байсан байх. Тэр үеийн лам нарын өдөр тутмын амьдрал нь хуралдаа хурна, номоо үзнэ, айлд залагдана. Манай хийдэд зоч нар, лүйжинч нар байсан. Гэхдээ цөөхөн байсан. Хандмаа нар байгаагүй. Хийдийн ойролцоо хятад наймаа байсан. Манай хийд 1935 онд хаагдсан. Би 1935, 1936 онд хар болсон. Манайх Хутагтынхтай ойрхон байсан. Хутагт манайд ирээд, манайх гүү барьчихдаг байсан. Тэгээд орой нь үеийн улсууд тоглож байгаад Хутагт “олон дахин ингэх биш дээ” гэж байсан. Тэгсэн удалгүй хоёр гурав хоногийн дараа баригдчихсан.

Хийдийн барилгыг нураагаад Авдарбаян сумд аваачиж барилга бариад ном судрыг нь хураадаг хүмүүс аваад явсан. Манай хийдээс 50 гаран хүн баригдсан. Одоо манай хүрээнд сууж байсан миний үеийн хүн ганцхан байгаа. Төв аймгийн Баян суманд Дорж гэж надаас хоёр ах хүн бий. Би 1937, 1938 онд цэрэгт явсан. Багийн дарга, агент хийсэн. Мал малласан. Дэчинравжаалан хийдэд ирээд удаагүй, одоо 3 жил болж байна.

Хийдээ нэг сэргээсэн. Одоо суудаг хүн байхгүй болсон. Одоо хааяа нэг ч болсон нэг хурал хурдаг байгаа даа.

Хүрээний зүүн урд талдаа Цогчэн дуган, түүний баруун талд Жүдийн дуган, Жүдийн дугантай зэрэгцээд Манбын дуган, Манбын дуганын зүүн талд Ламын дуган. Зүүн хүрээний тэнд нэг сүм байсан юм. Лам нарынхаа суудгийг Зүүн хүрээ, Баруун хүрээ гэж нэрлэнэ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нүгэл буяныг ялгаж мэдэх ариун сайхан сэтгэлтэй байж буян их хийгээсэй. Шажин улам их дэлгэрч, Монгол улсууд сайн сайхан явах болтугай.